



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1/07

Улаанбаатар хот

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах арга хэмжээний тухай" 2012 оны 222 дугаар тогтоолын 11, 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр хураамж, үйлчилгээний хөлс, хандив тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий дэд зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд зөвлөлийн дарга: С.Баасандолгор

Байгаль орчин, Хөдөө аж ахуй, дэд бүтэц, хот нийтийн аж ахуйн асуудал хариуцсан орлогч дарга

Нарийн бичгийн дарга: Ю.Энхтунгалаг

Байгаль орчин, ногоон байгууламж хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Э.Бүрэнтөгс

13 дугаар хорооны Засаг дарга, Туул тосгоны захирагч

М.Эрдэнэбулган

Мэргэжлийн хяналтын хэлтсийн байгаль орчны хяналтын улсын байцаагч

Г.Гансүх

Татварын хэлтсийн татвар хураалтын тасгийн дарга

Б.Батжаргал

Элс, хайрга, дайрга үйлдвэрлэгч компаниудын Холбоо ТББ-ын Гүйцэтгэх захирал

Ч.Батболд

"Эх Дэлгэрмөрөн" ХХК-ийн захирал

Н.Батбаатар

"Эверласт" ХХК-ийн менежер


Ч.Ганбаатар

"Мааньт Хараат" ХХК-ийн захирал

Д.Дүгэрсүрэн	"Орд талст" ХХК-ийн захирал
Х.Алтанцацралт	"Мөнх ногоон амьдрал" ТББ-ын тэргүүн
Ж.Үүрийнжин	Шинэ суурьшил, эрүүл аюулгүй орчин ТББ-ын Гүйцэтгэх захирал
Ж.Баярсайхан	12 дугаар хорооны ИНХ-ын дарга
Г.Жаргалбат	13 дугаар хорооны иргэн
Ц.Дуламсүрэн	14 дүгээр хорооны иргэн

2. Дүүргийн дэд зөвлөлийн ажлын төлөвлөгөөг жил бүрийн 12 дугаар сард багтаан батлуулах, тайлангийн мэдээллийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр дүүргийн Засаг даргад танилцуулж ажиллахыг дэд зөвлөл /С.Баасандолгор/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.ГАНХУЯГ